

**“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 02 дүгээр сарын 15 - ний өдөр

дугаар 26/10

Дархан –Уул аймаг

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.8.1, 8.8.3 дахь заалтууд, тус компанийн ТУЗ-ийн 2026 оны 02 сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дархан нэхий ХК-ийн 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг нэгж хувьцаанд 0,226 төгрөг буюу нийт 250,000,000 (хоёр зуун тавин) сая төгрөг байхаар тогтоосугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг хууль тогтоомжийн дагуу Хувь хүний орлогын албан татвар болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ТӨХК-аар дамжуулан 2026 оны 4 сарын 30-ны дотор багтаан олгосугай.
4. Ногдол ашиг хуваарилахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Дархан нэхий ХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Гэрэлмаа/, ерөнхий нягтлан бодогч /З. Оюунтуяа/ нарт тус тус үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Э. БАТСАЙХАН